



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2015 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/377

Улаанбаатар хот

Дэрэвгэр жиргэрүүг түүж бэлтгэх, гадаад улсад гаргах
зөвшөөрөл олгохыг түр хугацаагаар хориглох тухай

Байгалийн ургамлын тухай хуулийн 4 дүгээр зүйл, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.4, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.5.3.3 дахь заалт, “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол орны ховор ургамлын жагсаалтад орсон Дэрэвгэр жиргэрүүг *Saposhnikovia divaricate*/ устгах аюулд орохоос урьдчилан сэргийлэх, биологийн нөөцийг хамгаалах, экологийн шаардлагыг харгалзан түүж бэлтгэх, гадаад улсад гаргах зөвшөөрөл олгохыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл 5 жилийн хугацаанд түр хориглосугай.

2. Дэрэвгэр жиргэрүүг *Saposhnikovia divaricate*/ 2015 онд холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл авч түүж бэлтгэсэн аж ахуйн нэгжүүдэд байгалийн ургамлыг гадаадад улсад гаргах зөвшөөрлийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор багтаан олгохыг зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, орон нутагт зохих арга хэмжээ авч ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Р.Дэжид/-т даалгасугай.

САЙД



Н.БАТЦЭРЭГ